



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/839

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 15 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газраас Ховд хотын нийтийн эзэмшлийн зам дагуу ургасан модонд тайралт хийх ажиллагааны зардалд 2710.0 мянган төгрөг /хоёр сая долоон зуун арван мянган/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 2710.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн
А/839 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХОВД ХОТЫН НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ЗАМ ДАГУУ УРГАСАН МОДОНД ТАЙРАЛТ
ХИЙХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

ДД	Байгууллагын нэр	Ашигласан материалын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /төгрөг/
1.	Аймгийн онцгой байдлын газар	1. Дружба хөрөө	1	265000.00	265000.00
		2. Дружба хөрөө	1	320000.00	320000.00
		3. Дружба хөрөөний ир	5	20000.00	100000.00
		4. Будаг	18	5000,00	90000,00
		5. Багс	5	2000.00	10000.00
		6. Шатахуун			350000.00
		7. Хоол, хүнс			1575000.00
Дүн					2710000.00

-oOo-